


ЭРДЭМ СОЁЛ, ДУУ ХУУРЫН ХҮР БУУСАН ӨРГӨӨ



2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

Гарчиг

- 1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн
- 2.Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн
- 3.Байгууллагын үйл ажиллагааны үр дүн
- 4.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал
- 5.Бусад мэдээлэл, Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн:

Өргөө нь Монгол Улсын хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөр, Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Засгийн Газраас батлагдсан төсөл хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтууд, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөхөөр батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн үйлчилгээний албанд тавигддаг зарчим, шаардлага болон холбогдох заалтуудыг хангаж, нийслэлийн өмчийн эд хөрөнгийг бэлтгэх, бүртгэх, ашиглах, хамгаалах, түрээслэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, НИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж ирлээ.

“Галын болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай хамгаалах тухай” Нийслэлийн засаг даргын А/278 тоот захирамжийн хүрээнд “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа соёл, урлаг, үзвэр үйлчилгээ, зах худалдааны төвүүдийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, галын болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргав.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардагдах хөрөнгийн төсвийг хийв.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах орон тооны бус комисс байгуулан ажиллаж эхлээд байна.
- Хөдөлмөр аюулгүй байдлын тусгай самбар булантай боллоо.
- Шинээр галын багаж болох хүрз, сүх, лоом, хөрөө, жоотуу, галын хувин, галын хорны суурь худалдан авч зохих газруудад байрлуулсан.



- 1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нутгийн захиргааны байгууллагуудын бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилт, үр дүн бүх түвшинд ил тод нээлттэй, хариуцлагатай болж, иргэдийн хяналтыг бий болгон, сайн засаглалтай хот

болгохоор дэвшүүлсэн зорилтыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллаж байна.

Хоёр: Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн.

2.1. Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа.

Байгууллагын үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын **01 дүгээр хавсралтын** дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар гаргаж, холбогдох материалын хамт НЗДТГ-ын Хяналт Шинжилгээ Үнэлгээний хэлтэст хүргүүлдэг боллоо.

2.2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт:

2.2.1. Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН БИЕЛЭЛТ

Нийслэлийн Соёлын Төв өргөө 2018 он

Д/Д	Арга хэмжээ болсон он сар өдөр	Захирамж гарсан он сар өдөр дугаар	Товч утга	Биелэлт	Мөнгөн дүн
1.	2018.01.22	2013.01.18 А/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Нийслэлийн Газрын харилцааны олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 14.00-18.00 цагийн хооронд зохион байгуулав. 4 цаг	12000000
2.	2018.02.02	2013.01.18 А/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	НИТХ-аас СХД-ийн ахмадуудтай хийсэн уулзалт 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 14.00-16.00 цагийн хооронд зохион байгуулав. 2 цаг	6000000
3.	2018.02.09	2013.01.18 А/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	НИТХ-аас СБД-ийн ахмадуудтай хийсэн уулзалт 2018 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 11.00-13.00 цагийн хооронд зохион байгуулав. 2 цаг	6000000
4.	2018.03.14	А/41	Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 97 жилийн ойг тэмдэглэх тухай	Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах гэрээний 1.6-дахь заалтын дагуу Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 97 жилийн ойг тохиолдуулан “Батлан	12000000

				хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах өдөрлөг"-ийг 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 10.00-14.00 цагийн хооронд зохион байгуулав. 4 цаг	
5.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	НИТХ-ын арга хэмжээ 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 11.00-14.00 цагийн хооронд зохион байгуулав. 3 цаг	9000000
6.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Төрийн тусгай хамгаалалтын 90 жилийн ойн арга хэмжээ 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 11.00-14.00 цагт зохион байгуулагдав. 3 цаг	9000000
7.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Одонтой ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх, 555 ээжид алдарт эхийн одон гардуулах ёслолын арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 12.00-14.00 цагийн хооронд зохион байгуулав. 2цаг	6000000
8.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	"Монгол, Орос их санаачлага-2018" арга хэмжээний хүрээнд ОХУ-ын И.Моисеевын нэрэмжит Ардын дуу бүжгийн үндэсний чуулгын тусгай тоглолтыг 2018 оны 06 дугаар сарын 7.8-ны өдрийн 19.00-20.30 цагийн хооронд зохион байгуулж, сургуулилтыг 7,8-ны өдрийн 09.00-17.00цагт хийв. Тоглолтын цаг 3, сургуулилт 16 цаг	Тоглолт 9000000+ Сур - 7500000
9.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	НАЗЭХолбоо Хариу нэхдэггүй буянтан арга хэмжээ 2018 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 11.00-15.00 цагийн хооронд зохион байгуулав. 4 цаг	12000000
10.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах,	Улсын баяр наадмын хүндэтгэлийн концертын	Концерт 12000000+

			төлбөрөөс чөлөөлөх	сургуулилтыг 6 дугаар сарын 17-ноос 7 дугаар сарын 10-ны өдрүүдэд нийт 82 цаг хийж, хүндэтгэлийн концерт 15.00-17.00, 18.00-20.00 цагуудаас 2 удаа 4 цаг боллоо.	Сургууилт 41000000
11.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	“Хотын нийтийн тээвэр” замын хөдөлгөөний оновчтой шийдлүүд зөвлөгөөнийг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 08.00-13.00 цагт зохион байгуулав.	15000000
12.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны гала тоглолтын бэлтгэл сургуулилтыг 2018 оны 10 дугаар сарын 26-ны 10.00-17.00 цагт, 27-ны 10.00-17.00 цагт, 28-ны 09.00-13.00 цагт нийт 18 цаг, тоглолтыг 14.00-17.00 цагт зохион байгуулав.	Тоглолт 9000000 Сургууилт 9000000
13.		2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 379 жилийн ойн баярын концертын сургуулилтыг 2018 оны 10 дугаар сарын 29-ний 09.00-14.00 цагт хийж, 15.00-18.00 цагт концертыг зохион байгуулав. Сургууилт 6 цаг, концерт 3 цаг үргэлжлэв.	Концерт 9000000 Сургууилт 3000000
	ДҮН				186500000

Жич: 2018 оны байдлаар Нийслэлийн Засаг даргын захирамжаар 111 цагийн бэлтгэл сургууилт, 54 цагийн 13 удаагийн тоглолт арга хэмжээ зохион байгуулав.

2.2.2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийн хэрэгжилт.



- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр үр дүнгийн гэрээг байгуулж, 2 дугаар сарын 06-ны өдөр захирал, ахлах нягтлан бодогч нар хөрөнгө оруулгын мэдүүлгээ өгсөн.
- Шилэн дансны хуулийн дагуу 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн мэдээллүүдийг цаг хугацаанд нь шилэн дансны нэгдсэн системд оруулж ажиллалаа. Энд батлагдсан төсөв сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн

харьцуулалт, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ зэрэг багтаж байгаа юм.

- ✓ Мөн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлын хариуцан ажиллаж, тайланг цаг тухайд нь Сангийн яаманд илгээж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 70 шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь байршууллаа.
- ✓ Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан. 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг “Мандах мотиваци” аудитын байгууллагаар хийлгэж **“Санхүүгийн тайлангаа холбогдох хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, нягтлан болох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн холбогдох заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн, санхүүгийн зөрчилгүй”** гэсэн дүгнэлт авсан.
- Сар шинийн баяр, улсын баяр наадмын амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарийг захирлын тушаалаар батлуулан томилж, техникийн болон ямар нэгэн саад гэмтэл, осолгүй хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.
- Байгууллагын 30 жилийн ойг угтаж үйлчлэгч нарын үйлчилгээнд өмсөх хувцсыг ёслолын цагаан цамц, улаан хантааз, хар юбкаар жигдрүүлж, гадна талбайн үйлчлэгч, слесарь, цахилгаанчин нарын ажлын хувцсыг шинэчилж өглөө.

2.2.3. Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт. Тухайлбал:

1.Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь 2018 оны 02 дугаар сарын 12-ний өдрийн 11-14 цагийн хооронд бүх нийтийн их цэвэрлэгээ хийж гүйцэтгэлээ. Үүнд: нийтийн эзэмшлийн гудамж талбай, байгууллагын эргэн тойрны явган хүний зам талбайн хог хаягдал, хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэж, байгууллагын гадна шат болон довжооны хог хаягдлыг цэвэрлэж тээвэрлүүлэн, гэрлийн шон дээрх зарлал, сурталчилгааны хуудсыг хуулж, цэвэрлэх, байшингийн дээвэр дээрх цас, мөсийг буулгаж цэвэрлэлээ. Цэвэрлэгээнд манай байгууллагын 50 гаруй ажиллагсад идэвхитэй хамрагдлаа.



2. Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11-14 цагийн хооронд бүх ажилчид их цэвэрлэгээ хийж гүйцэтгэлээ. Үүнд: нийтийн эзэмшлийн гудамж талбай, байгууллагын эргэн тойрны явган хүний зам талбайн хог хаягдал, хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэж, байгууллагын гадна шат болон довжооны хог хаягдлыг цэвэрлэж тээвэрлүүлэж цэвэрлэлээ. Мөн байгууллагын дотор болон гадна талын хана, шал, үүдний том шилэн хаалганууд, угааж их цэвэрлэгээ хийлээ. Цэвэрлэгээг өдөр болгон тогтмол хийж ажиллаж байна. Цэвэрлэгээнд манай байгууллагын 30 гаруй ажиллагсад идэвхитэй хамрагдлаа.



3. 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 11-13 цагийн хооронд бүх ажилчид их цэвэрлэгээ хийж гүйцэтгэлээ. Үүнд: нийтийн эзэмшлийн гудамж талбай, байгууллагын эргэн тойрны явган хүний зам талбайн хог хаягдал, байгууллагын гаднах орчны 50 метр хүртэлх зам талбайн шарилж, зэрлэг ургамлыг зулгааж, байгууллагын гадна шат болон довжооны хог хаягдлыг цэвэрлэлээ. Мөн байгууллагын дотор болон гадна талын хана, шал, үүдний том шилэн хаалганууд, угааж их цэвэрлэгээ хийлээ. Цэвэрлэгээг өдөр болгон тогтмол хийж ажиллаж байна. Цэвэрлэгээнд манай байгууллагын 60 гаруй ажиллагсад идэвхитэй хамрагдлаа.



1. “Улаанбаатар марафон-2018” олон улсын гүйлтийн уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийн хуралдаанд тухай бүр захирал Б.Байгалмаа оролцлоо.
- “Улаанбаатар марафон-2018” гүйлтийг 5 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулах ажлын хэсгийн хүмүүсийн болон гадаадын зочид, гүйгчдийн хувцас өлгөх, хадгалах, халуун цай, ус ундаагаар үйлчлэх цэгүүдийг өөрийн байранд ажиллуулав.



2.2.4. Үйл ажиллагааны гүйцэтгэл сайжруулах дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- Захиргааны зөвлөлийн хурлыг хуваарийн дагуу хийж, Нийслэлийн байгууллагуудад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй www.edoc.ub.gov.mn цахим программаар гадагш 32 бичгийг илгээж гаднаас 66 албан бичгийг хүлээн авч, 66 албан бичгийг шийдвэрлэж хэрэгжилтийг хангалаа.
1. ХХОАТ-ийн хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх талаархи сургалт татварын ерөнхий газрын иргэний танхимд 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 11.00 цагт болсон бөгөөд уг сургалтанд тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн, нярав Б.Баярчимэг нар оролцлоо.



2. Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын талаарх ойлголтыг сайжруулах зорилгоор Худалдан авах ажиллагааны газраас нийслэлийн харъяа газруудад зохион байгуулсан сургалтанд 2018 оны 1 дүгээр сарын 25-ны 14.00 цагаас дулааны инженер Ж.Дуламжав, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар оролцлоо.



3. Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шилэн дансны цахим систем мэдээллээ хэрхэн шивэх, анхаарах асуудлын талаарх сургалтыг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15 цагт Нийслэлийн Засаг захиргааны V байр “Иргэний танхим”-д зохион байгуулсан бөгөөд ахлах нягтлан бодогч

Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн, нярав Б.Баярчимэг нар оролцлоо.

4. НЗДТГазраас КРІ /гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт/-ийг танилцуулах, нэвтрүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан бөгөөд урилгаар “Гүйцэтгэлийн төгөлдөршил” ХХК-ны менежер Өлзийбуян удирдан явууллаа. Уг сургалтанд зохион байгуулагч У.Урантогос, дулааны инженер Ж.Дуламжав нар оролцлоо.
5. НСТӨ-ний захиргаа КРІ /гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт/-ийн тухай ойлголт авах, түүнийг байгууллагадаа хэрхэн зөв хэрэгжүүлэх талаар Удирдлагийн академийн багшаас сургалт авлаа. Уг сургалтанд албадын дарга нар болон холбогдох гүйцэтгэх албан тушаалтнууд хамрагдлаа.



6. Нийслэл дэх Төрийн Аудитын газар, Нийслэлийн Санхүү Төрийн Сангийн хэлтсээс нийслэлийн харъяа газруудын дарга, нягтлан бодогч нарт “Төсвийн захирагчдын санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх нь” сэдэвт зөвлөгөөн 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд захирал Б.Байгалмаа, ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар оролцлоо.



7. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газраас нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа үзвэр үйлчилгээний газруудын удирдлагуудад ХАБЭА-ын сургалтыг 2018 оны 6 дугаар сарын 08-нд зохион байгуулсан. Уг сургалтанд дулааны инженер Ж.Дуламжав, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар хамрагдлаа.
8. Нийслэлийн мэдээлэл технологийн газраас 9 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй программ хангамжуудийг холбосон “UB ERP нэгдсэн системийн сургалт багш” сургалтанд Д.Цогжаргал, Б.Баярчимэг нар хамрагдлаа.
9. 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем /edoc/ -н хэрэглээ ашиглалтыг сайжруулах нэгдсэн сургалтанд Д.Цогжаргал хамрагдлаа.
10. 11 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн үйлчилгээний “Цахим шилжилт”-ын нээлт, танилцуулах сургалтанд инженер Д.Мөнхбаяр, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар оролцлоо

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн:

3.1. Хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил, үр дүн.

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёл урлагийн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, “Нийслэлийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” үүргээ амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлж ирлээ.

Тус зорилтын хүрээнд нийслэл, хөдөө орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлт, уран бүтээлчид, урлагийн байгууллага, иргэдийн тоглолт, арга хэмжээний захиалгыг урьдчилан авч, сар бүр зохион байгуулах ажлын график гарган ажиллаж, давхардсан тоогоор **157** удаагийн соёл урлагийн үзвэр, үйлчилгээ, хурал зөвлөгөөнд тайз, гэрэл, дууны тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, **234** мянга гаруй хүнд соёлч боловсон үйлчиллээ. Үүнд:

Монгол улсын ерөнхийлөгч Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэдтэй хийх уулзалт,

Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ын дарга Баярсайхан иргэдтэй хийх уулзалт,

УИХ-ын гишүүн Саранчимэг эхчүүд эмэгтэйчүүдтэй хийх уулзалт,

Яруу найрагч Лхамноржмаагийн уран бүтээлийн цэнгүүн,

Морин хуур наадам,

Шинэ үе продакшны “Найзууд” тоглолт,

Мөрөөдлийн театрын “Сошиал ертөнцийн гол дүр” тоглолт,

“Хулангийн үдэш” цэнгүүн,

Сүхбаатар дүүргийн 1000 ээжийн баяр,

“Их хотын бүсгүйчүүд” цэнгүүн,

МУГЖ Уянга “Эрхэмсэг” тоглолт,

Нийслэлийн цэргийн баяр,

“Ирээдүйн мистер” тэмцээн,

UBS-ийн бүжгийн тэмцээн,

ХХАА-н салбарын “Хамтдаа хөгжье” VIII зөвлөгөөн,

Түмэнжаргалын “Дурсамж” уран бүтээлийн үдэшлэг,

Сүлд чуулгын концерт,

Дуучин Дашцэрэнгийн уран бүтээлийн концерт,

ОХ-ны Буриадын улсын хүүхэлдэйн театрын Руслан Людмила, Үлгэр шоу тоглолтууд,
МУАЖ Мөнхшүрийн тоглолт,
Фауст драмын жүжиг,
Хэвлэлийн эрх чөлөөний өдрийн арга хэмжээ,
Морин хуурын чуулгын тоглолт,
МУГЖ Насантогтохын концерт,
“Алдрын одод” концерт,
Төрийн тусгай хамгаалалтын 80 жилийн ойн арга хэмжээ,
Хөгжмийн зохиолч Хүрэлбаатарын “Хөөрхөн Жинжиймаа” уран бүтээлийн цэнгүүн,
Найруулагч Болдын уран бүтээлийн тоглолт,
555 ээжид “Алдарт эхийн ” одон гардуулах ёслолын ажиллагаа,
Игорь Мосеевын нэрэмжит ардын бүжгийн чуулгын тоглолт,
Монгол Улсын Үндэсний Их театрын концерт,
Буриад дууны концерт,
МУИС-ийн 73 дахь төгсөлтийн диплом гардуулах ёслолын ажиллагаа,
Морин хуурын олон улсын VI наадмын нээлтийн тоглолт,
Тулгар төр байгуулагдсаны 2227, Их монгол улс байгуулагдсаны 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой Төрийн хүндэтгэлийн концерт
ТЭЦ-4 ХХК-ийн 35 жилийн ойн баярын хурал, концерт,
Хошин урлагийн Эмоци хамтлагийн “This is Mongolia” тоглолт,
БНХАУ-ын соёлын өдрүүдийн нээлт,
Баянжаргалын уран бүтээлийн тоглолт,
Баруун бүсийг чөлөөлсний 70 жилийн ойн хурал концерт,
Лекц,
БНХАУ-ын Жилинь мужийн урлагийн тоглолт,
Доржсамбуугийн уран бүтээлийн тоглолт,
НИТХ-ын төлөөлөгч Баярсайханы ахмадуудтай хийсэн уулзалт,
Маск продакшны “Монгол хүн та инээмсэглэ” тоглолт,
Үүрцайхын ахмадуудтай хийх уулзалт,
Нийслэлийн ахмадын байгууллагын 50 жилийн ойн хурал, концерт,
Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 80 жилийн ойн баярын концерт,
“Хотын нийтийн тээвэр замын хөдөлгөөний оновчтой шийдлүүд” зөвлөгөөн,
“Монгол хүн хүмүүжлийн аяны удирдах ажилтны II зөвлөгөөн”
“Хувиршгүй” тоглолт,
ОХ-ны Буриад улсын “Байкал” театрын Гала концерт,
Байкал театрын “Баргужин Төхөм” дуулалт жүжиг,
Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны наадам,
Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 379 жилийн ойн хүндэтгэлийн концерт,
Дуучин Баасандоржийн “Би яг ийм” тоглолт,
Эдийн засгийн албаны 80 жилийн ойн хурал концерт,
Аглуу интертаймент “Хөшиг нээгдэхэд нууц задарна” тоглолт,
Сити дээд сургуулийн 20 жилийн ойн тоглолт,
Нийслэлийн Соёлын төв өргөөний 30 жилийн ойд зориулсан “Ардын урлагийн тоглолт”,
“Бүжгийн гайхамшиг” тоглолт,
Эстрад рок, поп тоглолт,
Гала тоглолт,
“Амьдралынхаа эзэн нь бай” лекц,

Хятадын соёлын төвөөс зохион байгуулсан арга хэмжээ,
Гоёл-2019 наадам,

Бөртө чоно-2018 шагнал гардуулах ёслолын ажиллагаа,

Нийслэлийн Цагдаагийн газрын ажил дүгнэх тайлангийн хурал,

Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх албаны ажил дүгнэх хурал зэрэг тоглолт арга хэмжээний үеийн танхим, тайз, жүжигчдийн өрөө, ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, ажлын бэлэн байдлыг сайтар ханган, байгууллага уран бүтээлчидтэй гэрээ байгуулан төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж уран бүтээлчид, найруулагч нараас өндөр үнэлэлт авч ажиллалаа.

Тулгар төр байгуулагдсаны 2227, Их монгол улс байгуулагдсаны 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой Төрийн хүндэтгэлийн концертын бэлтгэл сургуулилтыг 6 дугаар сарын 17-ны өдөр 13 цагаас концертын зохион байгуулагчид ирж тайз, техник тоног төхөөрөмжтэй танилцав.

6 дугаар сарын 24-ний 10.00-11.30 цагт дуурийн дуучид, симциони найрал хөгжим, 6 дугаар сарын 25-ны 10.00-17.00 цагт бүх дуучид, хөгжимчид, бүжигчид, 6 дугаар сарын 26-ны 10.00-15.00 цагт, 6 дугаар сарын 27-ны 10.00-14.30 цагт сургуулилт хийж 15 цагаас хяналт, 6 дугаар сарын 28-ны 10.00-12.00 цагт хүүхдийн ордны сурагчид сургуулилт хийж, 17.00 цагаас шөнийн 02 цаг хүртэл дэлгэц угсарч байрлуулах, тохируулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 6 дугаар сарын 29-ний өдрийн 10.00-21.00 цагт, 6 дугаар сарын 30-ны өдрийн 20.00 –цагт техник суурилуулах тохируулах ажлууд хийгдэж, 7 дугаар сарын өдрүүдэд нэгдсэн сургуулилт хийж 7 дугаар сарын 10-ны өдөр 15.00,18.00 цагуудад 2 удаа нийслэлчүүддээ толилууллаа.

Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д. Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны гала концертын бэлтгэл сургуулилтыг 10 дугаар сарын 27-ны 09.00-17.00 цагт, 28-ны 08.00-13.00 цагуудад тус тус хийх нөхцөл бололцоогоор ханган ажиллаж 10 дугаар сарын 28-ны 14.00 цагаас толилууллаа.

Нийслэлийн 379 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн концертонд мэргэжлийн урлагийн байгууллагууд Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулга, бүжигчид, Улсын Филармонийн симфони найрал хөгжим, Монгол улсын Морин хуурын чуулга, МУГЖ Г.Эрдэнэцэцэг, Б.Мөнхбаатар, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн театрын гоцлол дуучид МУГЖ Ө.Уянга, дуучин Б. Батжаргал, Б.Энхнаран, балетийн гоцлооч Саруул, Эрдэнэболд, ОХУ-ын Гавьяат жүжигчин, Буриадын Ардын жүжигчин Дарима Дугданова, Буриад улсын Ардын жүжигчин Н.Мөнхзул, Үндэсний Урлагийн Их Театрын дуучин МУАЖ Д.Самбуу, МУГЖ Н.Амгалан, бүжигчид, ОХУ-ын Пирамид циркийн жүжигчид Анунгуа, Энхдөлгөөн, МУГЖ Г.Ариунбаатар, Улаанбаатар чуулгын дуучин МУГЖ Ганзориг, эстрадын залуу уран бүтээлчид Дэлгэрмөрөн, Б.Хонгор, С.Амармандах, Баярцэцэг нарын 200-аад уран бүтээлчдийн хамтарсан концертыг амжилттай зохион байгууллаа. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын уран бүтээлийн номерыг байгууллага болгон дээр нь очиж үзэн сонголтыг хийж өөр өөрийн байран дээр нь сургуулилтыг хийлгэсэн. Гоцлол дуучдын номеруудыг Улсын Филармонийн байран дээр симфони найрал хөгжимтэй 3 удаа сургуулилт хийлгэн өөрийн тайзан дээр 10 дугаар сарын 28, 29-нд нэгдсэн сургуулилтыг хийсэн. Концертыг 10 дугаар сарын 29-ний 15.00 цагаас нийслэлчүүддээ толилуулж хөтлөгчөөр МУСТА Н.Баянмөнх ажиллалаа.

Концерт маань нийслэлийн удирдлагаас сайн найруулгатай боллоо гэсэн сайшаалын үг сонссонд бид баяртай байна . Энэ концертыг хийхэд Соёлын төв

өргөөний нийт хамт олон сэтгэл зүрхээрээ гар нийлэн хамтарч нэгэн сэтгэлээр ажиллалаа. Концертын продюссероор Соёлын төв өргөөний захирал МУУГЗ Б.Байгалмаа , найруулагчаар МУСТА Б.Баттөр ажиллалаа.





3.2. Байгууллагын менежментийг боловсронгуй болгох, өмчийн ашиглалтыг сайжруулах талаар:

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түрээслүүлэх, соёл урлагийн арга хэмжээнд төлбөртэй ашиглуулах зорилт”-оо хангалттай хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал:



Өргөөний цогцолборын дулаан, цахилгаан, ус хангамжийн болон хог хаягдал, лифтийн үйлчилгээний аж ахуйн гэрээ улиралд байгуулж төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулж найдвартай ажиллагааг хангаж, өвлийн халаалтын дулаан, сантехник, цахилгаан, усан хангамжийн ямар нэгэн доголдол, аваар осолгүй ажиллалаа.

Түрээслэгч байгууллагуудаас 2018 онд ирсэн санал хүсэлтийг хугацаанд барагдуулж, 4 дүгээр сарын 1-нд салхивч, 5 дугаар сарын 1-нд халаалтаа хааж, засварын ажлуудыг хийж эхлээд байна.

Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагааны аюулгүй ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, техник тоноглолын хэвийн ажиллагааг хангах, хэт хүчдэлээс хамгаалах, аянгын хор уршгийг багасгах, зориулалттай газардуулгыг **1264680** төгрөгийн төсөв хийж шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Өмч хамгааллын комиссын ажлаа жилээр төлөвлөж, нийслэлийн өмчийг хамгаалах, ашиглалтыг сайжруулах зорилгоор цогцолборын “А” хэсгийн ажилчдын үүдний хэсгийн хана, таазыг хусаж цэвэрлэх, хүрээ булан хийх, фүжи шингэн цаас обой таазанд нааж, хананд корунд түрхэж удаан эдэлгээтэй чулуун хана хийв.





Цогцолборын "Г" хэсгийн 1 дүгээр давхрын тааз, хана хусаж цэвэрлэн, фүжи шингэн цаас, обой наах, гэрэлтүүлэг солих зэрэг ажлуудыг өөрсдийн ажилчдын хүчээр чанарын өндөр түвшинд хийж дуусгалаа.





3.3 Төсвийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийн тухай.

Манай байгууллага түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж ирлээ.


Өргөө нь НӨХГ-тай өмч эзэмшлийн гэрээ байгуулан ажиллаж байна. “Б”, “Г” хэсгийн ажлын байрыг НИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримтлан түрээсийн гэрээ байгуулж, НӨХГ-аар хянуулж, баталгаажуулж, хэрэгжилтийг хангаж, орлогыг бүрдүүлж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийлсэн **35** түрээслэгчтэй түрээсийн гэрээ, тоглолт арга хэмжээнд их танхимыг ашиглуулсны **59** түрээсийн гэрээг тус тус байгуулан гэрээний биелэлтийг хангуулж, НИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж, мөн Нийслэлийн өмчийн газартай байгуулсан эд хөрөнгийн түрээсийн 010101 тоот гэрээний дагуу нийслэлийн төсөвт **325** сая 693 мянга 760 төгрөг төвлөрүүлээд байна.

Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2018 онд бүрдүүлсэн орлого,

Д/Д	Он	бүрдүүлсэн орлого	Зардал санхүүжүүлэх	Төвлөрүүлсэн орлого	Захирамж	орлогын төлөвлөгөө	Хувь
1	2000	565,261.6	376,666.6	188,595.0	-	171,419.8	110.0
2	2001	789,100.5	576,733.0	212,367.5	10,500.0	176,391.8	120.4
3	2002	730,734.7	544,884.7	185,850.0	16,950.0	185,524.8	100.2
4	2003	704,033.9	496,433.9	207,600.0	43,000.0	206,400.0	100.6
5	2004	983,306.7	708,514.7	274,792.0	24,050.0	210,993.7	130.2
6	2005	1,120,315.8	856,616.4	263,699.4	87,150.0	263,699.4	100.0
7	2006	1,287,005.2	929,403.2	357,602.0	98,350.0	345,291.8	103.6
8	2007	1,513,564.6	1,050,507.7	463,056.9	6,225.0	375,009.6	123.5
9	2008	1,464,915.5	1,100,407.2	364,508.3	50,750.0	364,449.2	100.0
10	2009	1,267,699.4	1,017,699.4	250,000.0	74,400.0	249,340.6	100.3
11	2010	1,388,227.8	1,108,227.8	280,000.0	88,750.0	280,006.2	100.0
12	2011	1,552,116.9	1,253,688.1	298,428.8	78,575.0	298,428.8	100.0
13	2012	1,694,306.2	1,244,306.2	450,000.0	44,162.5	304,031.9	148.0
14	2013	1,637,720.6	1,257,720.6	380,000.0	147,500.0	377,545.2	100.7
15	2014	1,659,664.5	1,252,664.5	407,000.0	104,500.0	406,027.6	100.2
16	2015	1,580,607.1	1,157,707.1	422,900.0	89,500.0	422,000.0	100.2
17	2016	1,564,740.4	1,202,740.4	362,000.0	102,000.0	361,093.7	100.3
18	2017	1,476,899.4	1,115,651.6	361,247.8	115,252.2	361,247.8	100.3
19	2018	1,249,301.6	1,195,817.3	305,000.0	186,500.0	352,339.1	100.0
		24,229,522.4	18,446,390.4	6,034,647.7	1,368,114.7	5,711,240.8	

төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн дээрх хүснэгтээрх тооцоог графикаар харуулвал:



3.4. Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

Хүнийг хөгжүүлэх тусам чадвар нь өсөж, боловсорч хөгжихийн хэрээр сэтгэж, сэтгэхийнхээ хэрээр бүтээдэг онцлогтойгоороо бусад нөөцүүдээс давуу талтай юм. **Өөрөөр хэлбэл**, төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг цомхон, мэдлэг чадвартай, гадаад, дотоод орчны өөрчлөлтөд уян хатан зохицож чаддаг, төрийн албан хаагчдаар гүйцэтгүүлж, иргэдэд ойр, **хэрэгцээг** нь хангасан чанартай төрийн үйлчилгээг үзүүлэх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгохыг, улмаар байгууллагаас олон талт, өргөн цар хүрээтэй мэдлэг чадвар бүхий хүний нөөцтэй байх, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж байхыг **шаарддаг**.

3.4.1. Иймд Өргөөний захиргааны зөвлөлийн хуралдаанаас байгууллагын зорилт, чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай явуулахад тоо, чанарын шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх,

“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж, захирлын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны А/01 дүгээр тушаалаар **хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн удирдлагын зөвлөлийг** 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан баталж, зөвлөлийн гишүүдэд эрхэлсэн ажилтай нь уялдуулан албан хаагчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөл сайжруулах, техник хэрэгсэлээр хангах, сургах, мэргэшүүлэх, үйлчилгээ, харилцааны соёл эзэмшүүлэх, хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, зэрэг олон ажлыг даалгаж, хэрэгжүүллээ. /Энд тусгайлсан тайлан бэлтгэсэн болно/

3.4.2. Хүний нөөцийн бодлогын баримтлал, хүний нөөцийн талаарх бичиг баримтуудыг шинэчлэн, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэллээ. Энд: Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, Байгууллагын ёс зүйн дүрэм зэргийг шинэчилснээс гадна албан хаагчдын ажлын ирцийн бүртгэл, цаг ашиглалт, нийтийг хамарсан ажилд оролцсон байдал, захиргааны чөлөө олголт, эмнэлгийн хуудас, эмчийн магадлагаа зэргийг нарийвчлан ажил дүгнэхэд тооцдог боллоо.

Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн

ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ							
Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зурилог түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжи лтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэл зэр (мян.төг)	
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	9		
			Албан хаагчдын хамрагдсан байдал/ажлын байрны сургалт	80%	100%		
			Гадаад сургалтын тоо /туршлага судалсан/	0			
			Албан хаагчдын хамрагдсан байдал	6%	100%		
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70%-аас дээш	89%		
	Хэсгийн дундаж:						
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	53	100%	10980	
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварын болон хавсран ажилласны нэмэгдэл,	15	100%	27107,6	
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80%	100%		
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	73	100%		68584
	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	жилд 1 удаа	1 удаа		
			Албан хаагчдын хамрагдалт	100%	100%		
	Хэсгийн дундаж:						
	Үнэлгээний дундаж хувь:						

хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10 дүгээр хавсралтын дагуу тооцож гаргалаа.

Хүснэгтээс үзэхэд: Албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулалд 38975719 төгрөг, ур чадварын болон ажил хавсран гүйцэтгэсний

нэмэгдэлд 44137408 төгрөг, сар бүрийн хоол, унааны зардалд 12015000 төгрөгийг тус тус зарцуулсан байна. Зарим ажлыг тодруулж үзвэл:

Сургалтын чиглэлээр: Засгийн газрын үйлчилгээ аж ахуйн газраас зохион байгуулдаг ёс зүй, үйлчилгээний стандарт сургалтанд Б.Болормаа, Н.Тогтохжаргал, Э.Алтанцэцэг, Д.Элбэг нарыг хамруулж, мэргэжлийн үнэмлэхтэй болголоо.

Тусламж, тэтгэмжийн чиглэлээр: Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчдад тусламж олгох нөхцөл журам, байгууллагын дотоод журамд заасны дагуу гачигдалд тохиолдсон 8 хүнд **3250000** төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

Эрүүл мэндийн чиглэлээр: Улаанбаатар хотод болсон БНХАУ-ын соёлын өдрүүдийн үеэр зохион байгуулагдсан Хятад улсын ардын уламжлалт эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт албан хаагчдаа хамрууллаа.

Маркетинг үйлчилгээний албанд үйлчлэгчээр Б.Ганцэцэг, Б.Нямсүрэн Ч.Энхтуяа нарыг тус ажилд авч ажлын байраар хангалаа.

Албан хаагчдын шагналын тухай:

Байгууллагын 30 жилийн ойн баяраар дулааны диспетчер А.Санжаажав, Ж.Баатархуяг нар эрчим хүчний “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, Г.Майбаяр Эрчим хүчний яамны жуух бичгээр, барилгын засварчин Б.Бат-Эрдэнэ барилгын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, үйлчлэгч Ч.Заяа, Д.Энхцэцэг нар соёлын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, тайзны ажилтан Ч.Болдбаяр, лифтчин Т.Гэрлээ нар БСШУСЯ-ны жуух бичгээр, нярав Д.Энхмаа банк санхүүгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, дуучин Б.Хонгор МҮХАҮТ-ын “Хийморь” одонгоор, цахилгааны инженер Д.Мөнхбаяр Нийслэлийн хүндэт тэмдгээр, албаны дарга Ж.Дуламжав, И.Хишигжаргал, нярав Д.Энхмаа нар нийслэлийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, тайзны механик Ц.Наранцэцэг, диспетчер А.Санжаажав нар Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын өргөмжлөлөөр, дуучин Б.Хонгор, тооцооны нягтлан бодогч Ц. Пүрэвсүрэн нар Нийслэлийн Засаг даргын жуух бичгээр, жижүүр Г.Отгон, үйлчлэгч Б.Болормаа, Г.Амартүвшин, Н. Тогтохжаргал МААХҮЭ-ийн соёлын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, жижүүр Д.Энхтуяа, Г.Баасанжаргал, тайзны оператор Н.Жаргалсайхан, нар МҮЭ-ийн хүндэт тэмдгээр, тооцооны нягтлан бодогч Ц. Пүрэвсүрэн, тайзны ажилтан Ч.Болдбаяр нар Монголын Залуучуудын холбооны “Тэргүүний залуу” алтан медаль, дулааны диспетчер К.Ерэнбаатар, жижүүр Д.Болормаа нар “Хөдөлмөрийн алдар” медаль, МҮЭ-ийн хүндэт тэмдгээр мужаан Б.Санчирхүү, “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч” медаль, ахмад ажилтан Ш.Гансүх МАН-ын хүндэт тэмдгээр тус тус шагнагдлаа.

Мөн захирал Б.Байгалмаа “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжих, соёл урлагийг хүртээмжтэй олон талт үйлчилгээг нийгэмд хүргэх, төрийн томоохон хүндэтгэлийн , баяр наадмын, нийслэлийн ойн концерт, олон улсын хэмжээний үйл ажиллагааг чанартай гүйцэтгэж нийслэлийн иргэдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа нэр төртэй биелүүлж манлайлан ажилласан амжилтаараа “Шилдэг менежер”-ээр шалгарч ,Маркетинг үйлчилгээний албаны дарга У.Урантогос 2018 оны ажил үйлсээрээ шалгарч Нийслэлийн Хөдөлмөрийн аварга боллоо.

3.4.3. Нийт албан хаагчдыг цаг үеийн зохион байгууллалттай ажилд оролцуулж, ирээд хамт олондоо мэдээлэх, үр дүнг тооцох зэргээр чадавхижуулж, хариуцлагажуулж ажиллалаа. Тухайлбал:

1. ХХОАТ-ийн хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх талаархи сургалт татварын ерөнхий газрын иргэний танхимд 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 11.00 цагт болсон бөгөөд уг сургалтанд тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн, нярав Б.Баярчимэг нар оролцлоо.



2. Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын талаарх ойлголтыг сайжруулах зорилгоор Худалдан авах ажиллагааны газраас нийслэлийн харъяа газруудад зохион байгуулсан сургалтанд 2018 оны 1 дугаар сарын 25-ны 14.00 цагаас дулааны инженер Ж.Дуламжав, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар оролцлоо.



3. Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шилэн дансны цахим систем мэдээллээ хэрхэн шивэх, анхаарах асуудлын талаарх сургалтыг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15 цагт Нийслэлийн Засаг захиргааны V байр "Иргэний танхим"-д зохион байгуулсан бөгөөд ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн, нярав Б.Баярчимэг нар оролцлоо.

4. НЗДТГазраас КРІ /гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт/-ийг танилцуулах, нэвтрүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан бөгөөд урилгаар “Гүйцэтгэлийн төгөлдөршил” ХХК-ны менежер Өлзийбуян удирдан явууллаа. Уг сургалтанд зохион байгуулагч У.Урантогос, дулааны инженер Ж.Дуламжав нар оролцлоо.
5. НСТӨ-ний захиргаа КРІ /гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт/-ийн тухай ойлголт авах, түүнийг байгууллагадаа хэрхэн зөв хэрэгжүүлэх талаар Удирдлагийн академийн багшаас сургалт авлаа. Уг сургалтанд албадын дарга нар болон



холбогдох гүйцэтгэх албан тушаалтнууд хамрагдлаа.

6. Нийслэл дэх Төрийн Аудитын газар, Нийслэлийн Санхүү Төрийн Сангийн хэлтсээс нийслэлийн харъяа газруудын дарга, нягтлан бодогч нарт “Төсвийн захирагчдын санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх нь” сэдэвт зөвлөгөөн 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд захирал Б.Байгалмаа, ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар оролцлоо.



7. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газраас нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа үзвэр үйлчилгээний газруудын удирдлагуудад ХАБЭА-ын сургалтыг 2018 оны 6 дугаар сарын 08-нд зохион байгуулсан. Уг сургалтанд дулааны инженер Ж.Дуламжав, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар хамрагдлаа.



8. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газраас нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа үзвэр үйлчилгээний газруудын удирдлагуудад ХАБЭА-ын сургалтыг 2018 оны 6 дугаар сарын 08-нд зохион байгуулсан. Уг сургалтанд дулааны инженер Ж.Дуламжав, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар хамрагдлаа.
9. Нийслэлийн мэдээлэл технологийн газраас 9 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй программ хангамжуудийг холбосон “UB ERP нэгдсэн системийн сургалт багш” сургалтанд Д.Цогтаргал, Б.Баярчимэг нар хамрагдлаа.
10. 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем /e doc/ -н хэрэглээ ашиглалтыг сайжруулах нэгдсэн сургалтанд Д.Цогтаргал хамрагдлаа.
11. 11 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн үйлчилгээний “Цахим шилжилт”-ын нээлт, танилцуулах сургалтанд инженер Д.Мөнхбаяр, тооцооны нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн нар оролцлоо.

а. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

1. Архивын бичиг баримтын бүрдэлтээр

Манай байгууллага нь төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хугацаа болсон учир 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Нийслэлийн Архивын газартай хамтран Нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах 07/02 дугаартай гэрээ байгуулсан.

Энэхүү гэрээний хүрээнд Б.Баярчимэг /нярав/, Л.Болорчимэг нар Нийслэлийн Архивын газраас байгууллагын үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн баримтыг цэгцлэх ажлын зааварчилгаа авч, архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэн Г.Болорсүвд, М.Энхцэцэг нараас удаа дараагийн мэргэжил арга зүйн зөвлөгөө авч байгууллагын архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт, техник боловсруулалт хийж ажилласан.

ЭШТБ-ын ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Удирдлагын цаасан суурьт байнга хадгалах 2008-2017 оны баримт
- Түр хадгалах 2000-2017 оны баримт
- 70 жил хадгалах 1986-2017 оны баримт
- Соёлын төв өргөөний барилгын зураг төслийн 1976-1995 оны баримтуудад нягтлан шалгалт, ЭШТБ хийсэн.

Нягтлан шалгалтын ажлын үр дүнд

- Баримтын бүрдэл дутуу байсан удирдлагын байнга, түр хадгалах баримтыг олж илрүүлж, бүртгэл үйлдсэн.
- Хадгалах хугацаа дууссан мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй болсон баримтаас байнга хадгалах, 70 жил хадгалах баримтыг түүвэрлэн авч хадгалах хугацаа болон нэр төрлөөр ангилан ялгаж бүртгэл үйлдсэн.
- Он тус бүрт үүссэн баримтыг ХХНЖ-тай тулган, баримтыг бүрдлийг хангах талаар арга хэмжээ авч ажилласан. Бүрдэл дутуу баримтыг эрж сурвалжилж зарим баримтыг олж бүртгэсэн.
- Байнга хадгалах баримтын нэр, агуулгыг оновчтой, тодорхой болгон ач холбогдолоор нь дарааллуулсан.
- Ирсэн болон явуулсан бичгийг нягтлан шалгаж байгууллагын үндсэн үйл ажиллагаанд холбогдох байнга хадгалах бичгийг ялган авч байнга хадгалахаар бүртгэлд оруулсан.
- Захирлын тушаалыг үйл ажиллагаа болон хүний нөөцийн чиглэлээр ангилан төрөлжүүлж хэрэг бүрдүүлж байнга, 70 жил хадгалсан байсныг нягтлан шалгасан.
- Хугацаа дууссан 2000-2007 оны санхүүгийн баримтуудыг задалж нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудас, тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, захирлын тушаал, Үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээ зэрэг баримтуудыг түүвэрлэн авч нэр төрөл болон он цагаар ангилан төрөлжүүлж бүртгэсэн.
- Тусгай төрлийн баримтаар хэрэг бүрдүүлээгүй, хадгаламжийн нэгж үүсгээгүй байсныг эрж сурвалжлан олж хадгаламжийн нэгж бүрдүүлэх зааварчилгаа өгсөний дагуу, мөн байгууллагын 30 жилийн ойн арга хэмжээ, ном эмхэтгэл гаргахад зориулан байгууллагын үйл ажиллагаатай холбогдох гэрэл зураг, дүрс бичлэгийг цуглуулга байдлаар олж авсан. Ойн арга хэмжээний үйл ажиллагааны дараа хадгаламжийн нэгж үүсгэн, бүртгэлд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Барилгын Зураг төслийн баримтыг бүртгэлтэй тулган хадгаламжийн нэгж бүрээр зориулалтын хайрцагт хийж, хадгалалт, хамгаалалтын чанарыг сайжруулж ажиллаж байна.
- Ангилан нэр төрөл, он цагаар ялгасан баримтад баталгаа, ашиглалтын хуудас хийж, хуудас дугаарлаж, үдэж хавтаслан, нүүр бичилт хийж бүртгэл үйлдэв.

ЭШТБ-ын ажлын хүрээнд байнга, түр, 70 жил хадгалах баримтыг нэр төрөл, хадгалах хугацаагаар ангилан төрөлжүүлж, дараах техник ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үнд:

- Хадгаламжийн нэгжийг үдэж, хавтаслах
- Хуудас дугаарлах
- Дотоод товьёг хийх
- Нүүр бичилт хийх
- Гэмтэлтэй буюу стандарт бус баримт бичигт шилбэ уртасгаж наах
- Данс, бүртгэл үйлдэх
- Дугаарлах

- Тавиурт өрж байрлуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
ЭШТБ, нөхөн бүрдүүлэлтийн ажлын үр дүнд

- Төрийн архивт шилжүүлэх байнга хадгалах 1999-2013 оны 103 хн
- Төрийн архивт нөхөн бүрдүүлэх хугацаа болоогүй байнга хадгалах 2014-2017 оны 60 хн
- Түр хадгалах 2004-2017 оны 244 хн
- 70 жил хадгалах 1986-2017 оны 129 хн
- Устгах 1999-2016 оны 11 хэргийн 96 хадгаламжийн нэгж баримтад тус бүр данс, бүртгэл, акт үйлдэж НАГ-ын ББНШАЗК-ын 05 дугаар хурлаар хэлэлцүүлж батлууахаар танилцуулж байна.

№	Төрөл	Он цагийн хязгаар	Баримтын тоо
1	Байнга хадгалах баримтын данс /төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр шилжүүлэх/ Д№1	1999-2013	103 ХН
2	Байнга хадгалах баримтын данс /төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хугацаа болоогүй/	2014-2017	60 ХН
3	Байгууллагад байнга хадгалах	2006-2017	3 ХН
4	70 жил хадгалах баримтын бүртгэл Б №1	1986-2017	129 ХН
5	Түр хадгалах баримтын бүртгэл Б №1	2004-2017	244 ХН
6	Устгах хэргийн акт	1999-2016	11х/96 ХН

2. **Байгууллагад ирсэн хариутай албан бичгийн биелэлтийг хангаж**, 2018 онд 28 бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэсэн.

3. **Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар дараах ажлыг хийлээ.**

НЗД-ын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу өргөдөлд дурдсан асуудлыг бүрэн шийдвэрлэж, ирлээ. Байгууллагын захиргаанд иргэд, ажиллагсдын өргөдөл гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор ашиглагдаж байгаа www.smartcity.mn цахим хуудсыг хөтлөн, өргөдөл гомдлын нэгдсэн програмд ажилд орох, гарахыг хүссэн 34, буцалтгүй тусламж хүссэн 8 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн болно.

4. **Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр.**

1. Байгууллагын 30 жилийн ойд зориулан гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын 4 удаагийн “Алтан маск” шагналт Бурят улсын хүүхэлдэйн “Үлгэр”(Ульгер) театр нь 40 гаруй уран бүтээлчидтэй өөрсдийн тайз, декорацитай ирж нийслэлийн үзэгч хүүхдүүддээ ойн баярын бэлэг барьж 6 өөр төрлийн жүжигтэй ирснээс “Руслан Людмила хоёр”, “Ульгер” шоу, Торой банди, Айтёнок Пугола зэрэг жүжгүүдээрээ бэлэг барьсан. Анх удаа Ампитеатр буюу тайзан дээрээ үзэгчдээ суулгаж тоглосон нь үзэгчдэд маш өндөр сэтгэгдэл төрүүлж нийслэлийн үзэгч хүүхдүүддээ ойн баярын бэлэг барьж 2018 оны 4 дүгээр сарын 25,26-ны өдрүүдийн 15.00,19.00 цагт “Руслан Людмила хоёр”, 4 дүгээр сарын 27-ны 11.00,15.00,17.00 цагуудад, 28-ны 10.00 цагт “Ульгер” шоу тус тус амжилттай тоглуулж сонирхууллаа.



2. “Монгол, Орос их санаачлага-2018” арга хэмжээний хүрээнд ОХУ-ын И.Моисеевын нэрэмжит Ардын дуу бүжгийн үндэсний чуулга 90 гаруй уран бүтээлчдийн бүрэлдэхүүнтэй ирж, сургуулилтыг 7,8-ны өдрийн 09.00-17.00 цагт нийт 16 цаг хийж 2018 оны 06 дугаар сарын 7,8-ны өдрийн 19.00-20.30 цагийн хооронд 2 удаа чанарын өндөр түвшинд зохион байгуулж, гэрэл зургийн үзэсгэлэнг нийслэлчүүддээ толилууллаа.



3.2018 оны 9 дүгээр сарын 5,6,7-нд БНХАУ-ын соёлын өдрүүдийг амжилттай зохион байгууллаа.



4.9 дүгээр сарын 22-нд БНХАУ-ын Жилинь мужийн уран бүтээлчдийн тоглолтыг зохион байгууллаа.



5. Соёлын төв өргөөний урилгаар ОХ-ны Буриад улсын “Байкал” театр манай улсад 30 жилийн дараа 90 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр айлчлан тоглолт хийж Буриад улсын Төрийн шагнал хүртсэн “Баргужин Төхөм” дуулалт жүжиг, дэлхийд гайхагдсан бүжиг, дуу хөгжмийн Хүндэтгэлийн Гала тоглолтыг амжилттай зохион байгуулж, үзэгчдэдээ толилууллаа.



6. 2 жил тутамд уламжлал болон зохиогддог ардын урлагийн ХҮЭ-2018 наадмын 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаар сарын 02-ны өдрүүдэд 19 уран бүтээлчдийн бэлтгэл сургуулилтыг хийлгэн оролцууллаа. Манай уран бүтээлчид ардын болон уртын дуу, морин хуурын гоцлол, монгол үндэсний болон цэнгээнт бүжиг, гоцлол бүжиг, уран нугаралтын үзүүлбэрээ толилуулж Монголын уламжлалт болон орчин үеийн урлагийг хослуулсан нь үзэгчдийн болон наадмыг зохион байгуулах хорооноос өндөр үнэлэлт авлаа.

7.БНАСАУ-ын 2018 оны 4 дүгээр сард болсон олон улсын дуурийн дуулаачдын тэмцээнд элчин сайдын яамны ажилтнуудын дэмжлэгээр УДБЭТ-ын гоцлол дуучин Б.Батжаргал, Б.Энхнаран нарын бэлтгэлийг хангуулж, оролцуулсны үр дүнд Б.Батжаргал 2 дугаар байрын 5000 долларын шагнал, Б.Энхнаран тусгай байрын 1000 долларын шагнал хүртэж, амжилттай сайн оролцууллаа.

8.Мөн Буриад улсын Улаан-Үд хотын Дуурь бүжгийн эрдмийн театрын урилгаар Монголын сонгодог урлагийн сор болсон уран бүтээлчид Тэргүүн зэргийн “Чингис хаан” одонт, МУГЖ Г. Ариунбаатар, МУГЖ Ө.Уянга, МУГЖ Б.Эрдэнэтуяа, МУГЖ С.Мөнгөнцэцэг, ОХ-ны Буриад улсын ардын жүжигчин Н.Мөнхзул, дуучин Б.Энхнаран, О.Хүрэлбаатар, Б.Батжаргал нарын оролцсон “Монголын Алтан хоолойтнууд” концертыг 9 дүгээр сарын 24-ний өдөр Буриадын үзэгчид халуун дотноор хүлээж авлаа.

9.Улаанбаатар, Бээжин хотуудын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах “Улаанбаатар хотын өдрүүд” арга хэмжээний хүрээнд “Улаанбаатарын үдэш” тоглолтын хөтөлбөр гаргаж, 41 уран бүтээлчдийг хамрууллаа.

10. 2018 оны 12 дугаар сарын 8-16-ны өдрүүдэд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Мөнхжаргалын гадаад харилцаа хамтын ажиллагааны шугамаар ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Ажил мэргэжлийн дээд сургууль дээр Маркетинг үйлчилгээний албаны дарга У.Урантогос, Соёл-Эрдэнэ хамтлагийн дуучин Б.Хонгор, хөгжимчин Д.Баянзул, МУГЖ Н.Амгалан, ЦДБЭЧ-ын дуучин Ариунбаясгалан нар соёлын сургалтанд хамрагдаж ажил байдалтай танилцаад ирсэн.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал.

4.1. Төсөв, санхүүгийн ил тод байдлын хангаж, төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээ, тайлан балансыг цахимаар Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж нийтэд толилуулж ирлээ.

Мөн түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж хэвшлээ.

4.2. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, дараах ажлуудыг хийж, хэвшүүллээ.

4.2.1. Нийслэлийн Засаг даргын “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь цахим сайтад байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллаж ирлээ.

Мөн цаг үеийн мэдээллийн самбарыг ажилд оруулж өдөр тутмын ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж өдөр, тутмын шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын сайтыг тогтмол ажиллуулж хэвшүүллээ.

4.2.2. Үйлчилгээний ажлын ил тод байдлыг хангах зорилгоор санал, хүсэлт, сэтгэгдлийг нийтийн ариун цэвэр, угтах үйлчилгээ, үйлчилгээний ажилтны харилцааны соёлын чиглэлээр сэтгэл ханамжийн асуулгыг цахимаар болон 6 чиглэлийн асуулга хуудсаар авч хэвшүүллээ. .

4.3 Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангаж дараах ажлуудыг хийлээ.

- Албан хаагчдын ёс зүйн дүрмийг болон ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулж, тухай бүр шинэчилж байна.
- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Хүний нөөцийн хөгжлийн “Удирдлагын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг томилж, цахим хуудсанд байршуулсан болно.
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж, хэвшсэн. Улмаар албадын үйл ажиллагааны чиглэлээр нийт ажилчдын саналыг сонсож, дараа жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж, ажилладаг.
 - Байгууллагын “Вэб Сайт” шинэчлэх ажил
- Манай байгууллага Соёлын Төв Өргөө нь өөрийн одоо ашиглаж буй Вэб сайтаа (<http://www.stu.ub.gov.mn>) шинэчлэх зорилгоор Арт Саунд Продакшн ХХК тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. 2018 оны 11 дүгээр сарын

28 нд 18/25 дугаартай Цахим хуудас, дизайн бүтээх ажлын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Вэб сайт нь 5 үндсэн цэсээс бүрдэж байна.

- **1-р цэс Байгууллага**- 1.Байгууллагын танилцуулга 2. Бүтэц зохион байгуулалт, 3. Уран бүтээлчид 4.Түүхэн товчоо
- **2-р цэс Үйлчилгээ**- 1. Их танхимын түрээс 2.Оффисын түрээс 3. Үйлчилгээний орчин 4. Тасалбар худалдан авах
- **3-рт цэс Мэдээ мэдээлэл**- 1.Тоглолтын мэдээлэл 2. Соёл урлагийн боловсрол 3. Цаг үеийн мэдээлэл 4. Гадаад харилцаа хамтын ажиллагаа
- **4-р цэс Ил тод байдал**- 1. Хүний нөөцийн ил тод байдал 2. Байгууллагын ил тод байдал, Хууль эрх зүйн ил тод байдал
- **5-р цэс Шилэн данс** гэсэн 5 хэсгээс бүрдэж цэсүүд дотроо дэд цэсүүдээс бүрдэж орчин үеийн шаардлагад нийцүүлж мөн байгууллагын онцлог хэв шинжид тохируулан шинэчилж сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.
- Вэб сайтын шинэчлэх, байршуулах, үйлчилгээгээ өөрчлөх ажилтай холбоотойгоор манай байгууллага Үндэсний Дата Төвөөс олгодог Виртуал Сервер ашиглах ажлын шаардлага гарч байна.
- Вэб сайт байршуулах үйлчилгээгээ өөрчлөх дараах ажлын шаардлагууд гарч байна. Үүнд:
 - 1. Python/Django ашигласан вэбсайт байршуулах
 - 2. Python-ы custom library суулгах
 - 3. Apache WSGI ашиглах
 - 4. Бусад шаардлагатай тохиргоонуудыг хийж ашиглах
 - 5. Дор хаяж 100GB HDD, 1.5GB memory шаардлагатай
- Манай байгууллагын зүгээс Үндэсний Дата Төвд Виртуал Сервер ашиглах албан бичиг хүргүүлсэн бөгөөд Үндэсний Дата Төв Виртуал Сервер олгосны үндсэн дээр байгууллагын Вэб Сайт бүрэн хэмжээгээрээ ажиллаж эхэлнэ.

Тав. Бусад мэдээлэл, Өөрсдийн санаачлагаар хийсэн ажлын тухай:

Цаг үеийн ажлын шаардлагаар болон өөрсдийн санаачлага, байгууллага үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойгоор мэргэжлийн урлагийн байгууллагуудтайгаа хамтран 2018 оны 11 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд урлаг, соёлын наадам болгон Монгол Төрийн үндэсний их найрал хөгжим, гоцлол дуучдын нэгдсэн тоглолт, “Бүжгийн урлагийн гайхамшиг” тоглолт, Алдрын одод рок попын нэгдсэн тоглолт, Хүндэтгэлийн Гала тоглолтыг тус тус амжилттай зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлээ.

Эдгээр тоглолтуудад ОХ-ны Буриад улсын Соёлын сайд Соёлма Дагаева, ОХУ-ын гавьяат жүжигчин, Буриад улсын ардын жүжигчин Дарима Дугданова, Улаан-Үд хотын Дуурь Бүжгийн Эрдмийн театрын ерөнхий удирдаач Виталий Шевелев, концертмейстр ОХУ-ын ардын жүжигчин, Буриад улсын ардын жүжигчин Дарима Линховойн нар оролцож, бидний үйл ажиллагаа дэмжиж, хамтран ажилласан болно.

- 1. Монголын Төрийн их найрал хөгжим, гоцлол дуучдын хамтарсан тоглолт:**







2. “Бүжгийн урлагийн гайхамшиг” тоглолт.







3. Алдрын одод рок попын нэгдсэн тоглолт.





4. Хүндэтгэлийн Гала тоглолт.







5. Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Мөнгөн Улаанбаатар” цасны баярт оролцлоо.



Өргөө нь хамт олныхоо нөр их хөдөлмөр, хамтран ажилладаг та бүхнийхээ дэмжлэгээр орчин цагийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж, эдүгээ “Соёл урлаг, шинжлэх ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон талт арга хэмжээ зохион байгуулдаг, үе үеийнхний уран бүтээлчдийн хөгжин дэвждэг, урлаг соёл, дуу хуур, амжилт бүтээлийн дээжсээр ард түмнээ цэнгүүлдэг, “Нийслэлийн соёл урлаг, оюун ухааны гэгээрлийн төв” нь болон хөгжиж чадлаа.

Манай хамт олны ажлыг үнэлж, байгууллагын түүхэн хөгжлийн 30 жилийг тохиолдуулан Хангарьд одон, Тусгаар тогтнолын одон, Эрх чөлөөний одонгоор тус тус шагнууллаа.







Иймд та бүхнийг, **эрдэм соёл, дуу хуурын хур буусан нийслэлийн соёл, урлагийн төв голомт болсон** манай байгууллагын “Төрөөс соёл, урлагийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, нийслэлийн өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулж хөрөнгө нэмэх, нөхөх, үйлчилгээний соёлоо хангаж ажиллах чиглэлээр хийж байгаа бидний ажил”-ыг дэмжин, туслалцаа үзүүлж, хамтран ажиллана гэдэгт гүнээ итгэж байна.

Та бүхнийг хүндэтгэсэн:

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

Б.БАЙГАЛМАА

НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

П.СЭРСМАА